



**НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХӨГЖЛИЙН ГАЗАР**

**2021 ОН ЖИЛИЙН ЭЦСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, АГУУЛГА

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУССАН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- 1.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт
- 1.2 /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт

ХОЁР. УЛС, НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

- 3.1 Хот төлөвлөлт, судалгааны зорилтыг хангахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээ
- 3.2 Барилга, хот байгуулалтын зорилт арга хэмжээ
- 3.3 Хот байгуулалтын мэдээллийн санг эрхлэн хөтлөх зорилт арга, хэмжээ
- 3.4 Барилгын чанар, аюулгүй байдлын хяналтын зорилт арга хэмжээ
- 3.5 Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн зорилт арга хэмжээ
- 3.6 Хот дахин хөгжүүлэх талаарх зорилт арга хэмжээ
- 3.7 Хуулийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Газрын хөгжлийн орчны стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ

- 4.1 Зохион байгуулалт , бүтэц
- 4.2 Хүний нөөцийн ил тод байдал
- 4.3 Төрийн алба, албан хаагчтай холбоотой ажил
- 4.4 Төсөв, санхүүгийн ил тод байдал
- 4.5 Архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн шийдвэрлэлт
- 4.6 Мэдээллийн ил тод байдал
- 4.7 Шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажил

ТАВ. НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

- 5.1 Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт
- 5.2 Бусад байгууллагатай хамтран ажилласан ажлын талаар

ДҮГНЭЛТ

ЦААШИД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ

Нийслэлийн хэмжээнд Хот байгуулалтын газар, орон зайн төлөвлөлт, дахин төлөвлөлт, мэдээлэл, барилгын зөвшөөрөл, хяналтаар хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоол, шийдвэр, норм, дүрэм журамд нийцүүлэн Хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгох, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагааг Нийслэлийн нутаг дэвсгэрт нэгтгэн зохион байгуулж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигт туссан салбарын чиг үүрэгт ажлыг хэрэгжүүлж ажиллав.

НЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

1.1 БОДЛОГЫН БАРИМТ, БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 6.2 дах хэсгийг үндэслэн дараах бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг зохион байгуулан Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн хурлын тэмдэглэлийн хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн алба, хэлтэст зөвлөмж өгч ажиллав. Үүнд:

Бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилт

д/д	Бодлогын баримт бичгүүд	2020 оны байдлаар	2021 оны II дугаар улирал	2021 оны III дугаар улирал	2021 оны IV дугаар улирал
1.	Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр /20 зорилт, 28 арга хэмжээ/	-	-	73,4	91.7
2.	Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	100	-	-	100
3.	150 мянган айлын орон сууцны үндэсний хөтөлбөрийн биелэлт	47,7	-	-	76.6
4.	Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	100	-	-	-
5.	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн биелэлт	50	-	-	-
6.	Барилга, хот байгуулалтын Сайдтай байгуулсан гэрээний биелэлт /46 заалт/	-	63.4	-	88.9

7.	Байгаль Орчин, аялал жуулчлалын Сайдтай байгуулсан гэрээний биелэлт /2 заалт/	-	50	-	100
8.	Эрчим хүчний Сайдтай байгуулсан гэрээний биелэлт /5 заалт/	-	100		100
9.	Зам тээврийн хөгжлийн Сайдтай байгуулсан гэрээний биелэлт /3 заалт/	-	80	80	100
10.	Монгол Улсын Шадар сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2021 онд хамтран ажиллах гэрээний биелэлт /7 заалт/	-	-	-	92.8
11.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Барилга, хот байгуулалтын Сайд болон Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан гэрээний биелэлт /2 заалт/	-	65	-	100
12.	Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр			92,5	
13.	Нийслэлийн Эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл				88,8
14.	Нийслэлийн Засаг даргын Захирамжийн биелэлт				90
15.	Агаарын бохирдолтой тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлт	-	-	-	98.5

Хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт

<i>д/д</i>	<i>Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрүүд</i>	<i>202 оны II дугаар улирал</i>	<i>2021 оны III дугаар улирал</i>	<i>2021 оны IV дүгээр улирал</i>
1.	Ерөнхийлөгчийн зарлиг			100 1 зарлиг
2.	Үндэсний аюулгүй байдлын Зөвлөмж	100 1 зөвлөмж	100 1 зөвлөмж	100 3 зөвлөмж, 4 арга хэмжээ

3.	Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл	ҮБ 1 тэмдэглэл	100 1 тэмдэглэл, 4 арга хэмжээ	100 3 тэмдэглэл, 5 арга хэмжээ
4.	Улсын Их Хурлын тогтоол	66 1 тогтоол, 3 арга хэмжээ	-	100 2 тогтоол, 4 арга хэмжээ
5.	Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол	85 2 тогтоол, 2 арга хэмжээ	-	100 1 тогтоол, 2 арга хэмжээ
6.	Ерөнхий Сайдын захирамж	30 1 Захирамж	30 1 Захирамж	100 1 Захирамж
7.	Засгийн газрын тогтоол	100 3 тогтоол, 12 арга хэмжээ	65 3 тогтоол, 7 арга хэмжээ	92,5 4 тогтоол, 4 арга хэмжээ
8.	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	30 3 хуралдааны тэмдэглэл	50 5 хуралдааны тэмдэглэл	80.8 8 тэмдэглэл, 11 арга хэмжээ
9.	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөний биелэлт	-	-	85 /14 заалт/

1.2 КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ, ХОЛБОГДОХ ДҮРЭМ, ЖУРАМ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ:

Ковид-19 цар тахлын нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Нийслэлийн Онцгой комисс, Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, тайлан мэдээг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Онцгой комисст хүргүүлэн ажиллав. Үүнд:

- Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабт Газрын дарга 3 удаа хариуцлагатай жижүүрээр 24 цагаар ажиллан тухайн өдрийн хийсэн ажлын тайланг 11.00, 14.00, 19.00 цаг, дараа өдрийн 09.00 цагт нэгтгэн гаргаж, илтгэх хуудас бичин дараагийн жижүүрт хүлээлгэн өгч ажиллав.
- 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 02 дугаар сарын 05-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн 11, 15, 20 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх худалдаа, үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлж байгаа иргэдийг QR код уншуулж байгаа эсэх, халдвар хамгааллын дэглэм мөрдөн ажиллаж байгаад хяналт тавьж, халдвараас урьдчилан сэргийлэх, халдваргүйжүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн нийт 58 албан хаагч ажлын 9 өдөр, амралтын 2 өдөр,
- Орон сууцны барилгын агааржуулалтын хоолой шалгах Ажлын хэсэгт 2 албан хаагч,
- “Нэг хаалга – Нэг шинжилгээ” PCR шинжилгээнд давхардсан тоогоор 240 албан хаагч,
- Нийслэлийн Онцгой комиссын орон зайн дүн шинжилгээний багт 2 албан хаагч,
- Нийслэлийн хэмжээнд коронавирусийн халдвар нэмэгдсэнтэй холбогдуулан нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тусламж, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх зорилгоор 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрүүдэд ажиллуулах чиглэл ирүүлсний дагуу Сүхбаатар дүүргийн 11-20 дугаар хорооны 8 өрхийн эмнэлэгт давхардсан тоогоор 22 албан хаагч,
- Нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 732 тоот албан бичгийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамрагдалтыг эрчимжүүлэх, дархлаажуулалтын явцад хяналт

тавих, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх зэрэг ажилд 10 албан хаагч хуваарийн дагуу,

- Улсын Онцгой комиссын нэгдсэн шуурхай штаб болон Нийслэлийн Онцгой комиссоос ирүүлсэн чиглэлийн дагуу байгууллагын нийт албан хаагчдыг дархлаажуулалтын 3-р тунд хамруулах ажлыг зохион байгуулж, мэдээг тухай бүр цахимаар тайлагнаж ажилласан. 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 79 албан хаагч 3-р тунд хамрагдаж 94%, 2 албан хаагч ковидын халдвар аваад сар болоогүй, 5 албан хаагч эрүүл мэндийн шалтгаанаар хамрагдаагүй байна.
- Нийслэлийн Онцгой Комиссын даргын 2021 оны 15 дугаар тушаалын дагуу Газрын даргын баталсан хуваарийн дагуу Хан-Уул дүүргийн 9, 10 дугаар хороо сайжруулсан түлшний нөөц, хангалт, борлуулалт, түгээлт угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, түүхий нүүрсний хэрэглээнд хяналт тавих, Коронавируст халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунд иргэдийг идэвхтэй хамруулах ажлыг хорооны албан хаагчидтай хамтран зохион байгуулан ажиллав. Ажлын мэдээг өдөр бүр Нийслэлийн Онцгой комиссын цахим хаяг болон долоо хоног тутам Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газарт enkhee5980@gmail.com, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хөг, орчны бохирдол зохицуулалтын хэлтэст iska_1245@yahoo.com цахим хаягаар тус тус хүргүүлэн ажиллав.

Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх “Түр журам”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Газрын даргаар батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг Нийслэлийн Онцгой комисст nok@ulaanbaatar.mn/ цахим хаягаар хүргүүлэв.

Байгууллагаас дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

- Газрын 11 болон 13 давхрын ариун цэврийн өрөө, иргэдийг угтах хэсэгт гарын шингэн саван, гар ариутгагч тогтмол байршуулан “Зай барь”, анхааруулга, мэдээлэл хүргэх наалт, угтах хэсэгт хамгаалалтын тусгаарлалтыг хийж, давхрын ариутгал, халдваргүйжилтийг тогтмол хийлгэн, хүн хоорондын зайг баримтлан, иргэний QR кодыг уншуулан зөвлөгөө мэдээлэл өгөв.
- Ковид-19 “Эрсдэл” системийг гар утсандаа суулгаж, идэвхжүүлэх тухай, халдвараас урьдчилан сэргийлэх талаар “Нийслэлийн мэдээ” цахим хуудасны мэдээлэл, сэрэмжлүүлгийг байгууллагын uda.gov.uv.mn веб хуудас болон фэйсбүүк хуудсаар нийтэд түгээв.
- 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 05 дугаар сарын 07-ны өдрийг дуустал нийт 18 долоо хоног 10-30 хувиар ажиллах албан хаагчдын хуваарийг гаргаж, Нийтлэг үйлчилгээний газрын байр хариуцсан менежерт хүргүүлэв.
- 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр (Ковид-19)-ын тархалт ихсэж байгаатай холбоотой Тус газраас хүсэлт гарган Сонгдо эмнэлгийн явуулын шинжилгээний багийг ирүүлэн түргэвчилсэн шинжилгээнд 63 албан хаагч, эсрэг биетийн шинжилгээнд 15 албан хаагчийг хамруулав.
- Ковидын халдварын тохиолдол илэрсэн тухай бүрд Нийтлэг үйлчилгээний газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран голомтын ариутгалыг 11, 13 давхрын бүх өрөөнд ариутгал халдваргүйжүүлэх ажлыг хийж гүйцэтгүүлэв.
- Нийслэлийн хэмжээнд коронавирүсийн халдвар нэмэгдсэнтэй холбогдуулан нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тусламж, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх зорилгоор 2021 оны 10 сарын 04-ний өдрөөс 10 сарын 30-ны өдрүүдэд ажиллуулах чиглэл ирүүлсний дагуу Сүхбаатар дүүргийн 11-20 дугаар хорооны 8 өрхийн эмнэлэгт давхардсан тоогоор 22 албан хаагч ажиллав.
- Нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 12 сарын 03-ны өдрийн 732 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу 2021 оны 11 сарын 30-ны өдрөөс 12 сарын 10-ны өдрүүдэд дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамрагдалтыг

эрчимжүүлэх, дархлаажуулалтын явцад хяналт тавих, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх зэрэг ажилд 10 албан хаагч хуваарийн дагуу ажиллав.

ХОЁР. УЛС, НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГГИЖ БУЙ АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ:

2021 онд он дамнан хийгдэх Эрх шилжин ирсэн 3 ажилд Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1336 дугаар захирамжийн дагуу Захиалагчийн хяналт тавин ажиллав.

Аесн ХХК-ийн гүйцэтгэж буй Багахангай дүүргийн Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах ажил /175.000.000 төг/;

“Хот төлөвлөлт, судалгааны институт”-ийн гүйцэтгэсэн Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажил /1,438.200 төг/;

Нийслэлийн Засаг даргын 2021.03.22-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/189 дүгээр захирамжаар Барилга, байгууламжийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж паспортжуулах ажилд /135.2 сая төгрөг/

- Багахангай дүүргийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/528 дугаар захирамжийн дагуу Багахангай дүүргийн “Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл” боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр “Аесн” ХХК шалгарч, зөвлөх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2021 онд 21.743.750 төгрөгийн алданги тооцож, 148.750.000 төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2022 онд гэрээний үнийн дүнгийн 15 % буюу 26.250,00 төгрөгийг олгоно.

- Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/860, А/1201 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр, ХБХГ/ХТСИ-А/860-1-01 дугаар сунгалтын гэрээг 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр хүртэл тус тус “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай байгуулсан. Гэрээний дагуу тус ажлын гэрээний үнийн дүнгийн 80% буюу 1.100.000.000 /Нэг тэрбум нэг зуун сая/ төгрөгийн санхүүжилтийг олгосон.

- Барилга байгууламжийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж паспортжуулах ажил

Багц-1- Тоосго, зуурмагийн дээж авч лабораторид шинжилгээ хийх ажлыг “Эйч Ар Ви констракшн” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэж, эхний тайланг хянан үзэж, санхүүжилт болох 8.364.114 төгрөг, Багц-2: Багана, дам нуруу, хучилт, дээвэр, тэдгээрийн холбоосны угсралт болон ашиглалтын төлөв байдлыг тодорхойлж дүгнэлт гаргах ажлыг “МБ нөхөрлөл” ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж, эцсийн тайланг ирүүлснийг хянан үзэж, санхүүжилт болох 68.900.000 төгрөг, Багц-3: Туршилт судалгааны дараах сэргээн засварын ажлыг “Эйч Ар Ви констракшн” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэж, эцсийн тайланг ирүүлснийг хянан үзэж, санхүүжилт болох 17.270.120 төгрөг, Багц-4: Барилгын буурь хөрсөнд инженер-геологийн

дүгнэлт гаргах ажлыг “Таван үндэс” ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж, эцсийн тайланг ирүүлснийг хянан үзэж, үлдэгдэл санхүүжилт болох 36.806.800 төгрөгийг тус тус олгосон.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ:

3.1.1 Хот байгуулалтын баримт бичиг болон түүний тодотгол, шинэчлэл хийх үндэслэл, даалгаврыг боловсруулах, санал дүгнэлт гаргах, батлагдсан баримт бичгийг хэрэгжүүлэхэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд:

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, үе шаттай хэрэгжүүлэх:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 35 дугаар хуралдааны тэмдэглэлээр “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-ын дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулахыг Барилга хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарт даалгасан. Засгийн газраас өгсөн үүрэг даалгаврын дагуу Барилга, хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч хамтран “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар”-ыг боловсруулан Засгийн газрын 13 яам, Нийслэлийн 42 байгууллагуудаас санал авч, батлуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/860 дугаар захирамжийн дагуу “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ 2020 оны 10 дугаар сарын 12-ний өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 08-ны хооронд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулахаар зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Тус ажилд Захиалагчийн хяналт тавьж, эхлэл, дундын тайлангийн гүйцэтгэлийг хянаж Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсан.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хоорондох сарын хугацаанд иргэд, олон нийтээс <https://ulaanbaatar2040.mn/> вэб хуудас, Улаанбаатар 2040 Facebook, twitter, Instagram, YouTube зэрэг олон нийтийн цахим сүлжээний хэрэгслүүд болон харьяа хороогоор дамжуулан санал авах үйл ажиллагааг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай хамтран зохион байгуулсан. Санал асуулгад нийт 32,230 иргэн оролцож санал ирүүлснээс 12,907 иргэн цахимаар, 19,323 иргэн цаасаар өгсөн бол иргэдийн 91% нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг дэмжсэн санал ирүүлсэн.



Улаанбаатар 2040?
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
 Хоёр дахь удаагийн олон нийтийн цахим хэлэлцүүлэг

Зохион байгуулагч:  Барилга, хот байгуулалтын яам  Нийслэлийн Засаг даргаан Тамгын Газар  Хот байгуулалт, хөгжлийн газар  Хот төлөвлөлт, судалгааны институт

2021.09.08	2021.09.09	2021.09.10	10:00-14:00
<ul style="list-style-type: none"> Орон зайн төлөвлөлт Дагуул, хот тосгоны хөгжил Газар зохион байгуулалт Авто зам Нийтийн тээвэр Тээвэр ложистик Хүн ам зүй Нийгмийн дэд бүтэц 	<ul style="list-style-type: none"> Инженерийн бэлтгэл арга хэмжээ Ус хангамж, ариутгах татуурга Дулаан хангамж Хийн хангамж Цахилгаан хангамж Сэргээгдэх эрчим хүч Холбоо мэдээлэл 	<ul style="list-style-type: none"> Байгаль орчин Ногоон байгууламж Орчны бохирдол Хот хаягдлын менежмент Гамшгийн менежмент Аялал жуулчлал Түүх соёл Хууль, эрх зүй Эдийн засаг /Хөрөнгө оруулалт 	

Холбоо барих:  9444-2040 Бүртгэл: www.ulaanbaatar2040.mn 

Хот байгуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулахад шаардлагатай хөрөнгийг Барилга, хот байгуулалтын Сайдын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтад 300 сая, 2022 онд 338,3 сая төгрөг тусгагдсан.

Нийслэлийн 9 дүүрэг, 172 хороонд Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг танилцуулж санал авах хэлэлцүүлэг, сургалтын хөтөлбөрийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд дүүргийн удирдлагууд, хороодын Засаг дарга, хэсгийн ахлахууд, хот байгуулалтын салбар хариуцсан албан хаагчдад хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг танилцуулж тэдний санал, шүүмжийг авсан.

Монгол Улсын Засгийн газрын 14 яам, тэдгээрийн харьяа газрын удирдлага, салбарын бодлого төлөвлөлт хариуцсан албан хаагчдад хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг танилцуулж санал авах хэлэлцүүлгийн хөтөлбөрийг Нийслэлийн Засаг даргаар батлуулан, хөтөлбөрийн дагуу 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 22-ны өдрүүдэд санал, шүүмжийг авсан.

Монголын Архитекторуудын Эвлэлийн дэргэдэх Хот төлөвлөлт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн хурал болон Монголын Архитекторуудын Эвлэлийн гишүүд, архитекторуудад танилцуулах хэлэлцүүлгийг 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж тэдний санал, зөвлөмжийг авсан.

 УЛААНБААТАР 2040
УТАС: 9444-2040

“НИЙСЛЭЛ ХОТОО ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ”



ИРГЭН ТА САНАЛАА ӨГНӨ ҮҮ



09.29 - 10.29



WWW.ULAANBAATAR2040.MN



2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар, 2021 оны 11 дүгээр сарын 08-ний өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, дэмжигдсэн.

Тус ажлын эцсийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн 21 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хот байгуулалт, дэд бүтцийн хорооны өргөтгөсөн хуралдаан, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал дахь Ардчилсан намын бүлэг, Монгол Ардын намын бүлгийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж санал, зөвлөмж авсан.

2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус IV хуралдаанаар хэлэлцүүлж, “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг дэмжих тухай” 2021 оны IV-04/30 дугаар тогтоол гарсан.





2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Барилга, хот байгуулалтын Сайдын 239 дүгээр тушаалаар “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичигт экспертиз хийх орон тооны бус экспертүүд томилогдон ажиллаж, Магадлалын нэгдсэн дүгнэлт хийгдсэн.

2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Шадар сайдын ажлын албаны дарга, газрын дарга, албан хаагчдад танилцуулж санал, зөвлөмж авсан.

Барилга, хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020 оны 141, А/1015 дугаар хамтарсан тушаал, захирамжаар байгуулагдсан “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн 2021 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн хуралдаанаар эцсийн тайланг хэлэлцүүлж хүлээн авсан.

“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төслийн саналыг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж 2021 оны 02/4000 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.

Агаар орчны бохирдлыг бууруулах гэр хорооллын “Хөгжлийн үүд төсөл”-ийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төслийг батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллах:

Агаар орчны бохирдлыг бууруулах, гэр хорооллын “Хөгжлийн үүд” төслийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төслийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Тус төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 133 дугаар тогтоолоор батлуулсан.

“Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн ТЭЗҮ, ХЕТ боловсруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх, зураг төслийн ажилд захиалагчийн хяналт тавин ажиллана. /НЗДҮАХ-ийн 6.1.1.2-р арга хэмжээ/

“Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зураг төслийн эх үүсвэр Нийслэлийн 2021 оны төсөвт тус зураг төслийг боловсруулах хөрөнгийн эх үүсвэр тусгагдаагүй. Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тус ажлын хөрөнгийн эх үүсвэрийг тусгуулахаар 2021 оны 01/3123 тоот албан бичгээр хүргүүлэв.

Нийслэлийн ногоон бүс /зуслан/-ийн 4 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх боловсруулах ажилд захиалагчийн хяналт тавин ажиллах:

Нийслэл хотын Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дэх “Зуслангийн 4 ам”-ны ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах зургийн даалгаврыг Нийслэлийн Засаг даргаар батлуулан, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүлээлгэн өгсөн. Тус ажлын худалдан авах ажиллагаа, Захиалагчийн ажлын хяналт тавин ажиллахыг

Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд шилжүүлсэн. 2020 оны 06 дугаар сард үнэлгээний хороо байгуулагдан, гүйцэтгэгчээр “Ланд овнер” ХХК шалгаран гэрээ байгуулахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар батлуулахаар өгсөн боловч човид-19-ийн халдвартай холбоотойгоор төсөв татагдсан. Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд зуслангийн 4 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах төсвийг тусгуулахаар саналаа өгсөн.

“Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлыг Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, санал өгч ажиллах:

Нийслэл хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар хийгдэж байгаа “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-тэй уялдуулах зорилгоор “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-ын судалгаа, тайлан, мэдээллийг /тоон хэлбэрээр/ Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулж байгаа судалгааны багтай 3 удаагийн уулзалтыг зохион байгуулж Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хүн амын хэтийн тооцооллын талаар санал хэлэлцсэн бөгөөд Улсын хэмжээний нийт хүн амын хэдэн хувь нь Нийслэл Улаанбаатар хотод оршин суурьших шийдлийн талаар хүн ам зүйн төлөвлөлтийн зөвлөхүүд хамтран нарийвчлан хэлэлцэж хүн амын тооцоог эцэслэхээр шийдвэрлэсэн. Уулзалтаас гаргасан шийдвэрийн дагуу Улаанбаатар хотын хэмжээнд хийгдсэн хүн ам, нийгэм, эдийн засгийн төлөвлөлтийн таамаглалыг Барилгын хөгжлийн төвд хүргүүлж тус газраас Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн 2040 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй уул уурхай, зам тээвэр, үйлдвэр, эрчим хүчний мега төслүүдийн хүрээнд шууд болон шууд бусаар нэмэгдэж болох ажлын байр, түүнийг даган нэмэгдэх хүн амын тоо зэрэг хэтийн тооцоололтой холбоотой мэдээллийг авч ажлын уялдааг хангуулан ажиллаж байна.



Мөн Барилга, хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Үндэсний хөгжлийн газрын даргын 2021 оны 171, А-65, А/625 дугаар хамтарсан тушаал, захирамжаар байгуулагдсан урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдааг хангах ажлын хэсэг хуралдан, тус хурлаар Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Хүн амын нутагшил суурьшлын ерөнхий төсөл, Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын гүйцэтгэлийг танилцуулж ажлын хэсгийн гишүүдээс гарсан санал зөвлөмжийг бодлогын баримт бичигт тусгуулах ажлыг хамтран зохион байгуулав.

Нисэх, яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх, зураг төслийн ажилд захиалагчийн хяналт тавих:

Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах, зохион байгуулах чиглэлээр зураг төсөл боловсруулах ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх төсвийн саналаа Барилга, хот байгуулалтын Сайдад 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр албан бичгээр хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/427 дугаар захирамжаар Нисэх, Яармаг орчмын ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлыг Хот байгуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. Тус захирамжийн дагуу ажлын даалгаврыг боловсруулан Нийслэлийн Засаг даргаар батлуулан, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.


Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/651 дүгээр захирамжаар Улаанбаатар хотын төлөвлөлтийн “27 дугаар нэгж хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хувийн хэвшил, иргэдийн оролцоотой боловсруулахаар шийдвэрлэсэн. Захирамжийн дагуу зургийн даалгаврыг боловсруулан Нийслэлийн Засаг даргаар батлуулав. Зураг төслийн “Сонголт дизайн” ХХК нь Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан гүйцэтгэсэнд, Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, хот байгуулалтын чиглэлээр хийгдэж буй төсөл хөтөлбөрүүдийн уялдааг хангах зорилгоор Хан-Уул дүүргийн 4, 8, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн нийт 989 га талбайд боловсруулж буй хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний эхлэлийн тайланг хүлээн авч, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээж байна.

Хүй долоо худаг дахь “Монгол наадам цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулах:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/201 дүгээр захирамжийн дагуу Хүй долоо худаг дахь “Монгол наадам үндэсний спорт цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг боловсруулж, 2018 оны 1703/2018 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлт гарсан. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2019 оны 25 дугаар хурал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 78 дугаар тогтоол, Монголын архитекторуудын эвлэл Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус Мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 3 дугаар хурлаар тус тус хэлэлцүүлж дэмжигдсэн.

Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Богдхан төмөр замын чиглэл /трасс/-ийн Хүй долоо худаг дахь Монгол наадам цогцолбор орчмоор дайран өнгөрч байгаа хэсгийг хэрхэн төлөвлөсөн болон трассын сүүлийн эцэслэсэн хувилбарыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн бөгөөд Хүй долоо худаг дахь “Монгол наадам цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголд тусган ажиллах чиглэлийг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-т хүргүүлсэн.

Тус хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан холбогдох материал, танилцуулгыг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.



“Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар хорооны 210 га нутаг дэвсгэрт орон сууцны VII хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулах:

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/619, А/768 дугаар захирамжийн дагуу Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12-р хорооны нутаг дэвсгэрт 210 га талбайд “Орон сууцны VII нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол” боловсруулах ажлыг “Эн Эй Пи групп” ХХК гүйцэтгэсэнд захиалагчийн хяналт тавин ажиллав.

Тус ажлын эцсийн тайланг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүний хөгжлийн хорооны хурал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо, Байгаль орчин ногоон байгууламжийн байнгын хорооны хурлаар тус тус хэлэлцүүлж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 08/22 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулав.



Багахангай дүүргийн "хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк"-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулах:

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/528 дугаар захирамжийн дагуу Багахангай дүүргийн “Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл” боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр “Аесн” ХХК шалгаран гэрээ байгуулан, захиалагчийн хяналт тавин ажиллав.

Тус ажлын эцсийн тайланг 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 07 дугаар хурлаар хэлэлцүүлж хурлаас гарсан санал зөвлөмжийг тусгуулан эцэслэн хүлээн авч 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Монголын Архитекторуудын Эвлэлийн дэргэдэх Хот төлөвлөлт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан. Тус ажлын эцсийн тайланд улсын эксперт хяналт тавьж магадлалын нэгдсэн дүгнэлт ирүүлсний дараа Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралаар 2022 оны 1 дүгээр улиралд хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.



Хотын дэд төвийн төлөвлөлтийн үйл ажиллагаанд санал өгөх, зураг төсөл боловсруулах ажилд захиалагчийн хяналт тавин ажиллах:


Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/625 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотын төлөвлөлтийн Баруун-1 бүсийн 23 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Урбан девелопмент консалтинг групп” ХХК шалгарсан. Тус ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж, эцсийн тайланг 2021 оны Мэргэжлийн зөвлөлийн 07 дугаар хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсан.

Улаанбаатар хотын төлөвлөлтийн Баруун-1 бүсийн 23 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний эцсийн тайланг Монголын Архитекторуудын Эвлэлийн дэргэдэх Хот төлөвлөлт, архитектурын мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан. Тус ажлын эцсийн тайланд улсын экспертээр хянуулж магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах ажлыг “Урбан девелопмент консалтинг групп ХХК хариуцан ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/524 дугаар захирамжийн дагуу “Амгалан дэд төв”, “Шинэ төв”, “Сонсголон дэд төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ, “Дарь-Эх олон нийтийн төв”, Монел олон нийтийн төв” Тахилт олон нийтийн төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Зураг төсөл консалтинг” ХХК, “Бичил олон нийтийн төв”, “Ургах наран олон нийтийн төв”, Хайлааст олон нийтийн төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Арткон” ХХК тус тус шалгарсан

Тус олон нийтийн төв, дэд төвийн төлөвлөлтийн эхлэлийн тайланг хянан 2021 оны Мэргэжлийн зөвлөлийн 25 дугаар хурлаар хэлэлцүүлж, дундын тайлан хүлээн авахаар бэлдэж байна.

ОЛОН ТӨВТ ХОТЫН ТОГТОЛЦОО



3.2 БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ

Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн барилга, байгууламж болон нийтийн эдэлбэр газрын тохижилтын ажлын архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах, загвар төсөл батлах, олгосон зөвшөөрлийн хүрээнд хяналт тавих:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/89 дугаар захирамжаар Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Мэргэжлийн зөвлөлийн ээлжит 25 удаагийн хурлаар 1333 асуудлыг хэлэлцүүлснээс, 1113 асуудал дэмжигдэж, 887 архитектур төлөвлөлтийн даалгавар, 53 ажлын зургийн даалгавар, 488 барилгын эх загвар зураг батлав.

Тохижилт хийх 271 хүсэлтийг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн 265 байршилд Тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар болон загвар зургийг орчны болон төлөвлөлтийн авто зам талбайтай уялдуулан шийдэл гаргаж, явган болон авто зам, дугуйн замын хөдөлгөөний схем, тохижилтын хамт баталж, шийдвэрлэсэн.

Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр барих өргөтгөх авто зам, замын байгууламжийн хүсэлтийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар боловсруулж, загвар зураг зөвшилцөх, баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих:

Улс, нийслэл, хуулийн этгээдийн хөрөнгөөр шинээр барих, өргөтгөх авто зам, замын байгууламжийн 103 хүсэлтийг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 102 байршилд авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар батлагдсан.

Хөшөө, хүндэтгэлийн самбарыг хот төлөвлөлтөд уялдуулан уран сайхны шийдэл гаргах, үндэсний архитектурт нийцүүлж, шинээр байршуулах, шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах:

"Улсын нийслэлд хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбар байрлуулах журам"-ын хүрээнд Хөшөө дурсгал хүндэтгэлийн самбар байршуулах, загвар батлах комиссын хурлаар дараах тогтоолууд батлагдав. Үүнд:

- Монголын төр нийгэм, соёл, гэгээрэл, шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн, гоо зүй утга зохиолын судлаач, доктор, профессор, БНМАУ-ын Соёлын яамны нэгдүгээр орлогч Сайд асан Содномын Лувсанвандан, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн Бөхийн Бааст нарын

- хүндэтгэлийн самбар байршуулах асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 40 дүгээр тогтоолоор,
- Оросын Холбооны Улсын нэрт эрдэмтэн, Монгол судлаач, Түүхч Лев Николаевич Гумилёвын нэрэмжит хөшөө байршуулах асуудлыг хэлэлцэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 78 дугаар тогтоолоор тус тус батлагдав.

3.3 ХОТ БАЙГУУЛАЛТЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ ЭРХЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

3.3.1 Нийслэлийн хэмжээнд хот байгуулалтын кадастрыг хөтлөх, иргэн, хуулийн этгээдэд хот байгуулалтын мэдээллээр үйлчлэх, хот байгуулалтын мэдээллийн сангийн удирдлага зохион байгуулалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах:

Барилга, байгууламжийн тэг тэнхлэгийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгөх 303 иргэн, хуулийн этгээдийн 583 блок барилга байгууламжийн актыг хүлээн авч Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд бүртгэн, 303 акт үйлдэж өгөв.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний 2654 байр зүйн зураг хүлээн авч, хот байгуулалтын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг 796,2 га талбайгаар шинэчлэн баяжуулж, 2092 акт үйлдэв.

Хот байгуулалтын мэдээллийн санг шинээр хаяг дугаар авсан 1388 барилгын мэдээлэл болон нийслэл дэх сургууль, цэцэрлэгийн хамрах хүрээний зураглалаар баяжуулсан.

Орон зайн мэдээллийн санг шинэчлэн баяжуулах ажлын хүрээнд шинээр хаяг дугаар авсан 210 барилгын мэдээллээр барилгын мэдээллийн санг, Хот байгуулалтын мэдээллийн санд байр зүйн зургаар хүлээлгэн өгсөн 20,4 км авто зам 19,5 км холбооны шугам, 31,4 км цахилгааны шугам, 1,5 км далан суваг, 6,2 км ус зайлуулах шугам, 28,8 км дулааны шугам, 20,8 км ариутгах татуурга, 12.5 км усан хангамжийн мэдээллээр тус тус шинэчлэв.

Газрын даргын 2020 оны А/85 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд:

- Хот байгуулалтын мэдээллийн менежментийн систем дэх барилгын мэдээллийн сангийн "Төлөвлөгдсөн" хэсгээс давхардсан, төлөвлөлт өөрчлөгдсөн, Архитектур төлөвлөлтийн даалгавар хүчингүй болсон 475 барилга, тохижилт, дэд бүтцийн төлөвлөлтийн трассыг устгаж цэвэрлэв.
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 8/27, 25/21 дүгээр тогтоолын дагуу нийт 2550 барилгын хорооны мэдээллийг шинэчлэв.

3.3.2 Хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, мэдээллийн санг бүрдүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох:

- Ирсэн хүсэлтийн дагуу 145 иргэн, хуулийн этгээдэд байр зүйн дэвсгэр зургийг тоон болон хэвлэмэл байдлаар хүлээлгэн өгсөн.
- "Сонголт дизайн" ХХК-тай "Хот байгуулалт, хөгжлийн газрын нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах тухай" гэрээ байгуулан 2021/12 дугаартай акт үйлдэж, байр зүйн зургийг тоон хэлбэрээр хүлээлгэн өгөв.
- Ус суваг удирдах газар, Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-тай 2019 онд байгуулсан "Хот байгуулалт, хөгжлийн газрын нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах тухай" гэрээний дагуу акт үйлдэж байр зүйн зургийг тоон хэлбэрээр хүлээлгэн өгсөн.
- Ус сувгийн удирдах газартай 2019 онд байгуулсан "Хот байгуулалт, хөгжлийн газрын нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах тухай" гэрээг гэрээ дүгнэсэн протоколоор 3 жил сунган, акт үйлдэж, байр зүйн зургийг тоон хэлбэрээр хүлээлгэн өгөв.
- Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-тай 2019 онд байгуулсан "Хот байгуулалт, хөгжлийн газрын нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах тухай" гэрээний дагуу байр зүйн зургийг тоон хэлбэрээр хүлээлгэн өгөв.

- Нийслэлийн Авто замын хөгжлийн газартай “Газарзүйн мэдээлэл солилцох талаар хамтран ажиллах тухай” гэрээ байгуулж, 2021/03 дугаартай акт үйлдэн нийт 25 төрлийн мэдээллийг тоон хэлбэрээр хүлээлгэн өгөв.
- Хүсэлт ирүүлсэн 17 байгууллагад хот байгуулалтын мэдээллийн сангаас 91 төрлийн мэдээ мэдээллийг тоон байдлаар хүлээлгэн өгсөн.

Хот байгуулалтын мэдээллийн сан дахь орон зайн өгөгдлөөр сэдэвчилсэн зураг бэлтгэн 25 байгууллагад 108 ш зургийг хэвлэмэл болон тоон хэлбэрээр хүлээлгэн өгөв.

3.3.3. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, талбай, хотхон хорооллыг нэршүүлэх, нэрэмжит болгох ажлыг зохион байгуулж, барилга байгууламжид хаяг дугаар олгох ажлыг хариуцан гүйцэтгэх:

Хан-Уул дүүргийн 8, 21 дүгээр хороо, Сонсголонгийн зам, Наадамчдын замын уулзвараас урагш Жаргалантын ам руу эргэх авто замын уулзвар хүртэлх гудамжийг “Архивчдын гудамж”, Хан-Уул дүүргийн 8, 14, 21 дүгээр хороо, Жаргалантын ам руу эргэх авто замын уулзвараас урагш Өлзийтийн шалган нэвтрүүлэх товчоогоор гарч Өлзийт хорооллын урдуур Шувуун Фабрикийн зам хүртэлхийг “Өлзийтийн зам” гэж нэршүүлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 98 дугаар тогтоолоор батлагдсан.

Хан-Уул дүүргийн 17 дугаар хороо, Зайсангийн гудамжнаас зүүн тийш Хан хиллс хотхоны хойд талын авто замын тойрог хүртэлх гудамжийг Фредерик Шопений нэрэмжит, Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамжнаас зүүн тийш Рерихийн гудамжны төгсгөл, Г.Лувсанцэвээний гудамж хүртэлх гудамжийг Любовь Сергеевна Соболевагийн нэрэмжит болгон нэршүүлж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдсан.

Улаанбаатар хот нийт 173 нэршүүлсэн гудамж, зам, талбайтай болж байна.

3.4 БАРИЛГЫН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ:


3.4.1 Өмчийн хэлбэрийг үл харгалзан нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа болон шинээр баригдаж буй, өргөтгөл шинэчлэл хийгдсэн барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн болзошгүй газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар, материалын бат бэх тогтвортой байх чанарт мэргэжлийн дүгнэлт гаргах:

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 17 барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт төлбөртэй үнэлгээ хийж, нийт 22.201.200 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн. Газар хөдлөлтөд тэсвэргүй, хийц, бүтээц нь ослын байдалтай 66 барилгад зохих арга, хэмжээ авах хүсэлтийг албан бичгээр Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Татварын газарт хүргүүлсэн.

Газар хөдлөлтөд тэсвэргүй, эрсдэлтэй төрийн өмчийн /сургууль, цэцэрлэг, эмнэлэг, албан контор гэх мэт/, болон орон сууцны барилгуудын дүгнэлт, тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлэн арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөсний үр дүнд төрийн өмчийн 16 барилга, нийтийн зориулалттай орон сууцны 37 барилгыг буулгаж, дахин барилгажуулах үйл ажиллагаа хийгдэж байна.

3.4.2 Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох:

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 841 /Барилга-278, цахилгаан-83, засвар тохижилт-3, буулгалт-21, Инженерийн шугам сүлжээ-26/ барилгын ажлын зөвшөөрөл шинээр олгож, 204 барилгын зөвшөөрөлд сунгалт хийж 4 барилгын зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулсан. Дундаж шийдвэрлэлтийн хугацаа 12.2 хоног байна.



Барилга угсралтын ажил хийгдэж дуусалгүй удаан хугацаанд зогссон, хотын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлж буй, орчны эрүүл аюулгүй байдлыг хангуулах шаардлагатай хотын төвд байрлах 10 барилгад Барилгын тухай хуульд заасан хамгаалалтын горимд шилжүүлэх, барилгын түр хашаа, саравчийг стандартын дагуу хийх, төсөл хэрэгжих хугацааг гаргаж ирүүлэх, орчны аюулгүй байдлыг хангуулах тухай зөвлөмжийг албан бичгээр хүргүүлсэн.

3.5 ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ

Улаанбаатар хотын хэмжээнд баригдаж буй барилга байгууламжийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, трассыг зөвшилцөх:

- Дулаан хангамж	269
- Усан хангамж ариутгах татуурга	322
- Цахилгаан хангамж	281
- Харилцаа холбоо	192
- Инженерийн бэлтгэл арга хэмжээ	30

Нийт **1094** инженерийн дэд бүтцийн ажлын зураг төслийг зөвшилцсөн.

Нийслэлийн нутаг дэвсгэрт инженерийн дэд бүтцийн хангамжийн ажлын даалгавар боловсруулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх:

2021 онд Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн сангийн хөрөнгөөр хэрэгжих инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах, 32 асуудлыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж хүргүүлсэн. Үүнд

- Дулаан хангамжийн шугам сүлжээ	16
- Цахилгаан хангамжийн шугам сүлжээ	10
- Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ	10
- Харилцаа холбооны шугам сүлжээ	7
- Инженерийн бэлтгэл арга хэмжээний чиглэлээр	21 буюу 64

Хот байгуулалтын мэдээллийн санд 46989 метр инженерийн шугам сүлжээний трассыг оруулсан. Үүнд:

- Дулааны шугам	5196 м
- Бохир усны шугам	11994 м
- Инженерийн бэлтгэл арга хэмжээ	29799 м

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна инженерийн шугам сүлжээний хийгдсэн ажил, цаашид шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоог гаргасан.

23 дугаар нэгж хороолол, Багануур, Багахангай үйлдвэр технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг хянан зөвшилцсөн.

Дэнжийн 1000 дэд төв, Дамбадаржаа дэд төвийн инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдэл, хөрөнгө оруулалт, үр ашгийн тооцоог хянаж, ажлын зураг төслийг хянан зөвшилцсөн. Ажлын зургийн даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн 07 дугаар хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Үүнд:

- Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Залуус-1 нэгж хорооллын гадна дулаан хангамж.
- Налайх дүүргийн 5 дугаар хороо, Гордокийн дулааны эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл, гадна дулааны шугамын ажлын зургийн даалгавар,

Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Залуус-1” нэгж хороолол, “Солонго-1”, “Солонго-2” нэгж хорооллын гадна инженерийн шугам сүлжээний хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулав.

Улаанбаатар хотын баруун хэсэгт барих 50 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станцын асуудлыг хэлэлцэж, “Сонгино 2020/110/35кВ-ын дэд станц”-ын дэргэд суурилуулан байгуулахаар дэмжиж баталсан.

“Налайх-110/10кВ-ын дэд станц”-ын дэргэд баригдах цахилгаан цэнэг хураагуурын станцын Архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан.

Өргөтгөн шинэчлэх Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр хийгдэх нийт 3.7хос.км дулааны шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн.

Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэх нийт 4.1 хос.км шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн.

3.6 ХОТ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих ажил:

Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах үндсэн эрхийг хангах зорилгоор Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих ажлыг Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын дагуу нийслэлийн хэмжээнд үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 4 удаагийн дүгнэлтээр Ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон нийтийн орон сууцны зориулалттай 344 барилгын ашиглалтыг хориглосон бөгөөд Нийслэлийн Засаг даргын 16 удаагийн захирамжаар Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн 170 барилгыг буулган, дахин төлөвлөж, барилгажуулах тухай шийдвэр гарсан.

	Ажлын явц	Багц	Барилгын тоо	Тайлбар
	Төсөл хэрэгжиж байгаа	30	81	30 багцын 81 барилга байна
	Төсөл хэрэгжихээс татгалзсан		4	Оршин суугчдын хүсэлтээр төсөл хэрэгжүүлэхээс татгалзсан.
	Төсөл хэрэгжүүлэгч сонгон шалгаруулах шаардлагатай	40	85	Сонгон шалгаруулалт зарлаж байна.
	Нийт	70	170	

2021 онд 211 айлын 11 барилга буулган барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Үүнд:

- Баянгол дүүргийн 04 дүгээр хороо, Давхар - 1, 2, 3, 4, 5 дугаар байр
- Баянгол дүүргийн 3 дугаар хороо, 22, 37 дугаар байр
- Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, Нэхмэлийн 12, 13, 17, 18 дугаар байр

2021 онд 266 айлын 2 барилга ашиглалтад орсон. Үүнд:

- Хан-Уул дүүргийн 2 дугаар хороонд 126 айлын 1 орон сууц
- Баянгол дүүргийн 17 дугаар хороонд 140 айлын орон сууц

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

2021 онд төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг нийт 4 удаа зарлаж Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцуудыг буулган, шинээр барих төсөл хэрэгжүүлэгчээр 10 аж ахуйн нэгж шалгарч, Нийслэлийн Засаг даргын захирамж, төсөл хэрэгжүүлэх батламжийг гардуулж газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчтэй гэрээ байгуулах эрх олгосон.

Нийслэлийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын судалгаа, загвар зураг төслийг боловсруулах хөрөнгийн саналаа албан бичгээр хүргүүлсэн.

ТОХИЖИЛТЫН АЖИЛ

2021 онд нийт 15 байршил чөлөөлснөөс 13 байршилд Тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан. Үлдсэн 2 байршил хайс, хаалт чөлөөлсөн байршил тул Тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар шаардлагагүй. Тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлагдсан 13 байршлаас 3 байршилд загвар зураг батлагдсан.

Тохижилтын ажлын архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан байршлууд:

1. Баянгол дүүрэг 93-р сургуулийн хойд талд /144M2/
2. Баянгол дүүрэг 6-р хороо, 6-р байрны баруун талд /100M2/
3. Баянгол дүүрэг орон сууцны 26/8-р байрны зүүн хойд талд
4. Баянзүрх дүүрэг 6-р хороо, бөхийн өргөөний урд талд /50m2/
5. Баянзүрх дүүрэг 6-р хороо, 21-р сургуулийн урд / 540m2/
6. Чингэлтэй дүүрэг 5-р хороо / 160M2/
7. Чингэлтэй дүүрэг 6-р хороо, 108-р цэцэрлэгийн орчим / 120m2/
8. Чингэлтэй дүүрэг 3-р хороо, геоэкологийн хүрээлэнгийн баруун талд /140m2/
9. Сүхбаатар дүүрэг 4-р хороо, 149-р цэцэрлэгийн урд талд /600m2/

10. Сүхбаатар дүүрэг 8-р хороо, цагдаагийн 1-р хэлтсийн урд /215м2/
11. Сүхбаатар дүүрэг 8-р хороо, 2-р сургуулийн урд
12. Сүхбаатар дүүрэг 1-р хороо, united апартамент хотхоны зүүн талд /200м2/
13. Сонгинохайрхан дүүрэг 17-р хороо, 1-р хорооллын арын зам дагуу / 2660м2/

Чөлөөлөхөөс өмнө



Чөлөөлсний дараа



3.7 ХУУЛИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн Засаг дарга болон Газрыг хууль шүүхийн байгууллагад төлөөлөн оролцох ажил:

Иргэн, хуулийн этгээдээс Нийслэлийн Засаг дарга болон тус газарт холбогдон үүсгэсэн захиргааны болон иргэний нийт 96 маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүргийн хүрээнд бүх шатны шүүх хуралд оролцов. 24 хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлүүлэв.

Тайлант хугацаанд нийт 335 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон.

Гэрээ, эрх зүйтэй холбоотой ажил:

Хот байгуулалтын чиглэлээр дотоод үйл ажиллагааны чиглэлтэй холбоотой иргэн, хуулийн этгээдтэй 64 гэрээг байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Үүнээс:

- Зөвлөх үйлчилгээний 37 гэрээ,
- Байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой 27 гэрээ

Гэрээ дүгнэсэн 23 протоколыг байгууллагын дотоод сүлжээнд байршуулан ажиллав.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төсөлд оролцогч талуудын байгуулсан 545 гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, дүгнэх асуудлыг зохион байгуулан ажиллав.

Эрх зүйн шинэтгэлийн ажил:

Барилга, хот байгуулалтын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс болон бусад нийслэлийн харьяа байгууллагуудаас ирүүлсэн 17 хууль, дүрэм, журмын төсөлд санал өгч, 14 захирамжийн төсөл боловсруулан батлуулав.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Газрын хөгжлийн орчны стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:

4.1 Зохион байгуулалт, бүтэц:

Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1000 дугаар “Зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” захирамжаар зохион байгуулалтын бүтцийн 8 нэгж, 100 албан хаагчийн орон тоотойгоор “Хот байгуулалтыг газар, орон зайн төлөвлөлт, дахин төлөвлөлт, мэдээлэл болон барилгын

зөвшөөрөл, хяналтаар хэрэгжүүлэгч байгууллага байх” зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1,2,3 дугаар хавсралтын дагуу тус Газрын 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, “Байгууллагын Стратеги төлөвлөгөө 2021-2024”-ийг тус тус боловсруулан батлуулж мөрдөн ажиллав.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 07/162 дугаар албан бичгээр ирүүлсэн “Нийслэлийн нутгийн Захиргааны байгууллагуудын 2020 оны ажлын үр дүнг үнэлэх” удирдамжийн дагуу 2020 оны үйл ажиллагааны үр дүнг шалган зааварлах шалгалтыг цахимаар тайлагнав.

Газрын албан хаагчдад зориулан www.erp.ulaanbaatar.mn, edoc системээр баримт боловсруулахад мөрдөх зөвлөмж, алба, хэлтсүүдэд тайлан, мэдээ, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах талаар, Ёс зүйн зөвлөлөөс нийтлэг зөрчил дутагдлыг арилгах, цаашид анхаарах асуудлуудын талаар тус тус зөвлөмж гарган албан хаагчдад танилцуулж, үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллав.

Барилгад хаяг дугаар олгох, байр зүйн зургийг мэдээллийн санд бүртгэх, тэг тэнхлэгийн актыг мэдээллийн санд бүртгэх, инженерийн шугам сүлжээний зурган мэдээллээр үйлчлэх зэрэг 6 төрлийн үйлчилгээний нийт 1584 хүсэлтээс Төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn-р 226, Нийслэлийн нэгдсэн цахим үйлчилгээний www.eservice.ulaanbaatar.mn 1358 хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн.

4.2 Хүний нөөцийн ил тод байдал:

Газрын албан хаагчдын мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, чадавхыг сайжруулах чиглэлээр 75 удаагийн сургалтад (цахимаар 58, танхимын 16) нийт давхардсан тоогоор 756 албан хаагч хамрагдав. Сургалтын дэлгэрэнгүй тайлан мэдээг улирал, хагас жилээр гарган байгууллагын дотоод сүлжээнд болон цахим хуудаст байршуулав. Үүнд: “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем ашиглах сургалт”, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд мэдээлэл оруулахтай холбоотой түгээмэл асуулт, хариулт өгөх сургалт”, “Мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудад зориулсан сургалт”, “Худалдан авах ажиллагааны тайлан мэдээний нэгдсэн системийн программ хангамжийн өөрчлөлт, хөгжүүлэлтийн талаарх сургалт”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж болон eDoc системийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр цахим сургалт”, “Өргөдөл, гомдлын асуудал хариуцсан албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх мэргэжил арга зүйн сургалт”, “Ус хангамжийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн ариутгах татуурга, бохир ус зайлуулах туршлага, шинэ шийдлүүд”, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан гарын авлагыг баталгаажуулах сургалт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, эрх зүй, нягтлан бодох бүртгэлийн дэд бүтэц, хувь хүний хөгжил, төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын өөрчлөлт” сэдэвт сургалт, “Татварын хууль тогтоомж, цаашид анхаарах асуудлууд”, “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Төрийн албан хаагчийн манлайлал ба гүйцэтгэлийн менежмент”, “Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, анхаарах асуудал” сэдэвт сургалт,

Сургалтын дэлгэрэнгүй тайлан мэдээг улирал, хагас жилээр гарган байгууллагын дотоод сүлжээнд болон цахим хуудаст байршуулав.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг “2020” шинэчлэн гаргасан 62, албан тушаалд томилогдсоноос хойш хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг 2020* мэдүүлсэн 32, их хэмжээний өөрчлөлт 2020+ мэдүүлсэн 7, нийт 101 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд авч, баталгаажуулав. 3 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахимаар мэдүүлж, Авлигатай тэмцэх газраар хянуулав.

Газрын үйл ажиллагаатай холбоотой А тушаал 35, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 97, нийт 132 тушаалыг боловсруулан баталгаажуулж, дотоод сүлжээнд цахимаар

байршуулав. Нийт 132 захиргааны шийдвэрийн хяналтын дагалдах хуудас хөтлөн, хувийн хэргийг бүрдүүлэв.

Газрын Захиргааны зөвлөлийн 26 удаагийн хурлын төлөвлөгөө гарган батлуулж, хурлын тэмдэглэлээр албажуулав.

4.3 Төрийн алба, албан хаагчтай холбоотой ажил:

Засгийн газрын болон Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор баталсан хууль эрхийн актуудыг үндэслэн албан хаагчдын цалин, зэрэг дэв, төрийн алба хаах хугацааны нэмэгдлийг шинэчлэх:

Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Захиргааны зөвлөлийн 2021 оны 2 дугаар хурлаар хэлэлцүүлж, газрын Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар хэсэг “Төлөвлөгөө, тайлан, түүнд тавих хяналт”, 8 дугаар хэсэг “Цалин хөлс, нэмэгдэл, олговор, шагнал урамшил” хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулж Газрын даргын 2021 оны А/01 дүгээр тушаалаар батлуулав.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” А/270 дугаар захирамжаар төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгогдсон 40 албан хаагчийн зэрэг дэв, түүний нэмэгдлийг Төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд <https://hr.csc.gov.mn/hub/login.html> оруулж, мэдээллийг шинэчлэв. Нийт төрийн захиргааны 84 албан хаагчаас 54 албан хаагч зэрэг дэвтэй байна. 2021 онд ахлах түшмэлийн дөтгөөр зэрэг шинээр 4 албан тушаалтан, дэс түшмэлийн дөтгөөр зэрэг шинээр 8 албан хаагч, зэрэг дэвээ ахиулсан 28 албан хаагч байна.

Газрын албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх:

Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл”, 276 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл шинэчлэн тогтоосон жагсаалт”-ыг тус тус баримтлан Газрын зохион байгуулалтын нэгж тус бүрийн төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоож Газрын даргын 2020 оны А/44 дүгээр тушаалаар батлуулав.

Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 16 ажлын байрны 19 сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалтыг зохих журмын дагуу зарлуулахаар мэдээлэл бүхий хүснэгт, сул орон тоо гарсан шийдвэрүүд, албан тушаалын тодорхойлолт зэрэг мэдээллийг Төрийн албаны нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэв. Төрийн албаны тухай хууль болон холбогдох журмын дагуу сул орон тооны мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулав.

Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан хэрэгцээнд шаардлагатай мэдээлэл, судалгааг тухай бүр цахимаар болон албан бичгээр хүргүүлж, тайлагнав.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Төрийн албаны зөвлөлийн даргын 2021 оны 72/188 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хяналт шалгалт хийх, зөвлөн туслах ажлын удирдамж”, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 03/5020 дугаар “Хяналт шалгалтын бэлтгэл хангах тухай” албан бичгийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл, зохих бэлтгэлийг хангаж ажиллав.

Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 101 албан хаагч батлуулж, төрийн үйлчилгээний 14 албан хаагч хөдөлмөрийн гэрээг байгуулан ажиллав.

Төрийн албаны тухай хууль, “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, Газрын Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу давхардсан тоогоор 91 албан хаагчид 45.836,272 төгрөгийн мөнгөн урамшуулал, 12 албан хаагчид шагналын дагалдах

1.650,000 төгрөгийн мөнгөн урамшуулал, 6 албан хаагчид 3.900,000 төгрөгийн тэтгэмжийг тус тус олгов.

2021 оны Сар шинийн баяр, Газрын харилцааны ажилтны өдөр, Ардын хувьсгалын 100 жилийн ой, Улсын их баяр наадам, Барилгын салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотын бүтээн байгуулалтын ажилд дорвитой хувь нэмэр оруулж, хот байгуулалт, газрын харилцааны салбарт тогтвор суурьшилтай, идэвх санаачилгатай амжилт гарган ажилласан албан хаагчдыг зохих журмын дагуу шагналд 71 албан хаагчийг нэр дэвшүүлж тодорхойлсноос 17 нэр төрлийн шагналаар 65 албан хаагчийг шагнуулав.

Газрын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 3 албан хаагчид 500,000 төгрөгийн тэтгэмж, урамшуулал, Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын Орон зайн дүн шинжилгээний багт ажилласан 2 албан хаагчид 2-5 дугаар сарын илүү цагийн нэмэгдлийг тус тус олгов.

4.4 Төсөв, санхүүгийн ил тод байдал:

Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль, дүрэм журмын хүрээнд төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, хөрөнгө оруулалтын дансны мэдээ, барьцаа дансны мэдээ, нэмэлт санхүүжилтийн дансны мэдээ, төсөв санхүүтэй холбоотой 6 бүлгийн 20 мэдээ тайланг хугацаанд нь байршуулж, шилэн дансны хөтлөлт, баяжилтыг хийж ажиллав.

2021 онд 1021088,3 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч, 46988,3 мянган төгрөгийн орлого олж 58415,9 мянган төгрөг зарцуулсан.

- Дугаарын үнэ – 18693,4 мянган төгрөг
- Зургийн үнэ – 10330,0 мянган төгрөг
- Тодорхойлолтын үнэ – 537,8 мянган төгрөг
- Барилгын чанарын дүгнэлт – 5986,0 мянган төгрөг
- Ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл – 8582,5 мянган төгрөг
- Архивын лавлагаа – 195,5 мянган төгрөг
- Бусад – 2663,1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Хөрөнгө оруулалтаар он дамжин хийгдсэн ажлын 661,393,0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон. Нэмэлт санхүүжилтийн дансаар “Нэг хаалга нэг шинжилгээ” арга хэмжээнд 3,804,0 мянган төгрөг зарцуулсан.

Газрын хэмжээнд нийт 22,237,671,3 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтад хяналт тавин ажиллав. Үүнд:

- Үндсэн хөрөнгө- 22,202,397,355.07 төгрөг,
- Аж ахуй- 25,925,352 төгрөг,
- Бичиг хэрэг- 7,723,633 төгрөг,
- Сэлбэг хэрэгсэл- 1,625,000.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт 94,157,070,75 төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг актлуулахаар 2021 оны 1/539 дугаартай албан бичиг хүргүүлэв. Албан бичгийн дагуу 94,157,070,75 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг акталж, 6 нэр төрлийн 9,849,499 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг устгалд оруулж, 28 нэр төрлийн 84,307,571,75 төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 365,900 төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 109,770 төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дансанд, 70 хувь болох 256,130 төгрөгийг Газрын дансанд тушаав.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны улсын тооллого”-д toollogo.1212.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулж гэрчилгээ авсан.

Нийслэл дэх Төрийн аудитад 2020 оны санхүүгийн тайлан шалгуулж, 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 172 дугаартай Зөрчилгүй дүгнэлт албан бичгээр ирсэн.

Тайлант хугацаанд нийт 54774,950 төгрөгийн бичиг хэрэг, 11649,810 төгрөгийн аж ахуйн материал худалдан авч, 54248,164 төгрөгийн бичиг хэргийн материал, 9055,171 төгрөгийн аж ахуйн материал олгов.

4.5 Архив албан хэрэг хөтлөлт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт:

Монгол Улсын Засгийн газрын 246 дугаар тогтоолын дагуу Газрын даргын 2021 оны А/22 дугаар тушаалаар байгууллагын Албан хэрэг хөтлөлтийн журам боловсруулан батлуулав.

Албан бичгийн шийдвэрлэлт:

Нийт	3957
Судлагдаж байгаа	55
Шийдвэрлэсэн	3895
Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	7
Шийдвэрлэлтийн дундаж	9 хоног байна
Шийдвэрлэлтийн хувь	99.8 %

Байгууллагаас нийт явсан 4116 бичгийг стандартын дагуу боловсруулан холбогдох газруудад хүргүүлсэн.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

Нийт	1156
Хугацаандаа байгаа	13
Шийдвэрлэсэн	1143
Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	8
Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн явц	10 хоног байна.

Газрын uda.ub.gov.mn цахим хуудсанд Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар бүр байршуулан ажиллав.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах 8 заалт бүхий 2021 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан Газрын даргаар батлуулав. Төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны 1/2990 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүлэв.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 03/77 дугаар албан бичгээр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын UB ERP системээр "Албан хаагч"-ийн өргөдөл, гомдол, хүсэлтийг бүртгэж байхаар чиглэл ирүүлсний дагуу 46 албан хаагчийн хүсэлтийг бүртгэж, шийдвэрлэлтийг тайлагнаж ажиллав.

Байгууллагын архивын үйл ажиллагаа:

Байгууллагын 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн 2092 баримтыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүлээн авч, данс бүртгэлийг шинэчлэн үйлдэв. Үүнд:

- ✓ Байгууллага дээр байнга хадгалах хувийн хэрэг 2007-2020 оны 9006 баримт,
- ✓ Байнга хадгалах 2012-2020 оны 5752 баримт,
- ✓ 70 жил хадгалах 1999-2020 оны 73 баримт,
- ✓ Түр хадгалах 2002-2020 оны 1450 баримт,
- ✓ Зураг төслийн 2002-2019 оны 439 баримт,
- ✓ Цахим баримт 173 баримт.

Нийт 16893 баримт байна.

2020 оны баримтыг архивд хүлээлгэн өгсөн тоон үзүүлэлт:

д/д	Нэгж	Байнга хадгалах баримт	Хувийн хэрэг	Түр хадгалах	Зураг төсөл	70 жил хадгалах	Цахим баримт	Нийт
1	Захиргаа, санхүүгийн хэлтэс	109	-	75	-	6	-	190
2	Ерөнхий Архитекторын ажлын алба	14	-	3	-	-	-	17
3	Хот төлөвлөлтийн хэлтэс	34	869	2	-	-	-	905
4	Хот байгуулалтын мэдээллийн хэлтэс	74	-	4	-	-	9	87
5	Барилгын чанар, аюулгүй байдлын хяналтын хэлтэс	304	-	10	-	-	-	314
6	Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс	5	-	4	-	-	-	9
7	Хот дахин хөгжүүлэх хэлтэс	97	376	54	10	-	-	537
8	Хууль, эрх зүйн хэлтэс	29	-	4	-	-	-	33
НИЙТ								2092

Барилгын хувийн хэрэг, зураг төслийн баримтыг төрийн архивын байнгын хадгалалтад шилжүүлэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг Газрын даргын 2021 оны А/26 дугаар тушаалаар байгуулав. Нийслэлийн Архивын газрын зааварлагч, арга зүйчийн заавар зөвлөмжийн дагуу 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд барилгын 2007-2017 оны 6568 хувийн хэрэг, зураг төсөл, техникийн 2002-2020 оны 436 баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх ажлыг гүйцэтгэв.

Газрын даргын 2020 оны "А" тушаал 91, "Б" тушаал-170 нийт 261 захирамжлахын баримт бичгийг архивын цахим санд бүртгэв.

Хадгаламжийн сан №2, №3 өрөөг нэгтгэн шинээр нягтаршуулсан шүүгээ авч, цэгцлэн хадгаламжийн нэгжийн байнгын баримтуудыг байршуулав.

Архивын лавлагаа, мэдээлэл авахаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 86 хүсэлтийг шийдвэрлэж, бүртгэл хөтлөн ажиллав. Үүнд:

- Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөс ирсэн 32 хүсэлт,
- Албан бичгээр ирүүлсэн 45 хүсэлт, (Edoc программ)
- Өргөдөл гомдлын нэгдсэн системээр ирүүлсэн 11 хүсэлт. (ERP систем)

Газрын албан хаагчдын албан хэрэгцээнд архивын 960 баримтыг 8 нэгжийн 46 албан хаагчид түр ашиглуулан, бүртгэл хөтлөв.

Хот байгуулалтын мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулах чиглэлээр холбогдох мэргэжилтнүүдэд 834 хувийн хэргийг түр ашиглуулан, бүртгэл хөтлөв.

Архивын лавлагаа хүссэн 26 аж, ахуйн нэгжийн албан бичиг, 9 иргэний өргөдлийг шийдвэрлэв. Газрын даргын "А" тушаал-91, "Б" тушаал-170- ийг бүрэн цахимжуулав.

4.6 Мэдээллийн ил тод байдал:

Байгууллагын цахим хуудсанд нийт 12 төрлийн 295 мэдээ мэдээлэл байршуулснаас:

- Цаг үеийн мэдээ	78
- Барилгын ажлын зөвшөөрлийн бүртгэл	9
- Мэргэжлийн зөвлөлийн хурал	32
- Бичгийн шийдвэрлэлт	24
- Өргөдөл гомдлын шийдвэрлэлт	10
- Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	32
- Газрын даргын тушаал	54
- Төсөв, санхүүгийн тайлан	20
- Хууль дүрэм журам	9
- Хүний нөөц	13
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	16
- Бусад	11

Газрын цахим хуудсаар 783222 иргэн, хуулийн этгээд хандан мэдээлэл авсан.

2021 оны хэвлэл, олон нийтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан газрын uda.ub.gov.mn цахим хуудас, Facebook page, ulaanbaatar.mn цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллээр газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг ил тод хүргэж ажиллав.

Газрын үйл ажиллагааг нээлттэй хурдан шуурхай болгох зорилготой видео танилцуулга олон нийтэд хүргэх ажлыг санаачлан I-UP мэдээллийн цонхыг эхлүүлсэн. I-UP мэдээллийн цонхоор "Нийтийн тээврийн сонголтоор Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах", "Архитектур төлөвлөлтийн даалгавар олгох", "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг шинэчлэн барилгажуулах төсөл" зэрэг мэдээллийг байршуулсан. Мөн "Их тойруугийн судалгаа", "Хүртээмжийн төсөл-Налуу зам" зэрэг мэдээллийг түгээв.

Газрын дотоод хяналт шалгалтын талаар:

Газрын 2021 оны Дотоод хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөө батлуулан, хэрэгжилтийг ханган хяналт-шинжилгээний ажлын тайланг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн санал зөвлөмж өгч ажиллав. Үүнд:

- Шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа үр дагавар үүсэж болзошгүй хэрэг,
- "Ашиглалтын шаардлага хангахгүй, нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төслийн ажил,
- www.eservice.ulaanbaatar.mn, www.e-mongolia.mn цахим программын үйл ажиллагаа болон үйлчилгээний материалын бүрдэл,
- Хот төлөвлөлтийн жижүүрийн зураг хөтлөх үйл ажиллагаа,
- Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн албан бичгийн хэрэгжилт.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Төрийн албаны зөвлөлийн даргын 2021 оны 72/188 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Хяналт шалгалт хийх, зөвлөн туслах ажлын удирдамж", Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 03/5020 дугаар "Хяналт шалгалтын бэлтгэл хангах тухай" албан бичгийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл, зохих бэлтгэлийг хангаж ажиллав.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 03/4653 дугаартай албан бичгээр тус газарт ирүүлсэн зөрчилтэй шийдвэрлэсэн гэх 600 өргөдөл, хүсэлтэд Газрын даргаар

батлуулсан удирдамжийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд хяналт шинжилгээ үнэлгээг хийв. Хяналт шинжилгээний ажлын дүнгээр:

- Хангалтгүй шийдвэрлэсэн гэх 409 өргөдлийн 283 өргөдлийг Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын 8 дугаар бүлэг “Өргөдөл, гомдолд хариу өгөх”-т заасны дагуу хангалттай хаасан,
- Хугацаа хэтрүүлэн хаасан 8 өргөдлийн 3 нь дээр дурдсан журмын 7 дугаар бүлгийн 7.4-т хугацаа сунгуулах хүсэлтийг Иргэд хүлээн авах төвөөс шийдвэрлээгүй, 10 дугаар зүйлийн 10.1-д зааснаар хугацаа хэтэрсэн өргөдөл гомдлыг шилжүүлсэн нь зөрчилд тооцох үндэслэл байхгүй,
- Шийдвэрлэх явцад зөрчилд тооцогдсон 189 зөрчлийн 44 нь ERP буюу Өргөдөл, гомдлын системийн алдаанаас үүдэлтэй байна. Системийн алдаа нь 2021 оны 03 дугаар сарын 25-аас 04 дүгээр сарын 09-ний өдрүүдэд хамаарах ба албан хаагчийн утсанд мессеж (sms) ирээгүй мөн ажлын компьютерт мэдээлэл харагдахгүй байснаас үүссэн гэж дүгнэсэн.

Дүнг Захиргааны зөвлөлийн 23 дугаар хуралд танилцуулж, нийт нэгжүүдэд цаг ашиглалт, өргөдөл, албан бичгийн зөрчил гаргахгүй санаачилгатай ажиллах үүрэг даалгавар өгөгдөв. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 11 дүгээр сарын 03-ны өдрийн 01/3569 дугаартай албан бичгээр хяналт шалгалтын дүнг хүргүүлэв.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт болон газрын цахим хуудасны хөтлөлт, хэвлэл мэдээлэл, олон нийтийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийх хяналт шинжилгээ үнэлгээг 4 үндсэн чиглэлээр, Газрын даргын тушаалаар байгуулагдсан байнгын ажиллагаатай 6 ажлын хэсгүүдийн төлөвлөгөө, тайланд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээг тус тус хийж, Захиргааны зөвлөлийн 25 дугаар хурлаар дүнг танилцуулсан.

Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчилгээ авах иргэн, хуулийн этгээдэд барилга, хот байгуулалт, дахин төлөвлөлт, газар орон зайн болон дэд бүтцийн чиглэлээр МРА системээс мэдээлэл өгөх, газраас үзүүлэх 22 үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, холбогдох хууль журмын дагуу ил тод, хурдан, тэгш, нээлттэй үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд нийт 7958 иргэн, хуулийн этгээдэд үйлчлэв. Нийслэлийн үйлчилгээний Дүнжингарав төвөөр 3321, Драгон төвөөр 2175, Мишээл төвөөр 1745, Оргил төвөөр 717 иргэн, хуулийн этгээдэд үйлчилсэн.

Төрийн үйлчилгээний нэгдсэн портал “e-mongolia” цахим системд Барилга барих хүсэлт, барилгад хаяг дугаар олгох, байр зүйн зураг, тэг тэнхлэгийн актыг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэх, инженерийн шугам сүлжээний зурган мэдээллээр үйлчлэх, архивын лавлагаа олгох зэрэг 6 төрлийн үйлчилгээг холбож, нийт 1358 үйлчилгээг цахимаар үзүүлсэн.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр баталсан “Дотоод аудитын ажлын удирдамж”, 10 дугаар сарын 15-ны өдөр баталсан “Дотоод аудит, хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Нийслэлийн Дотоод аудитын газарт байгууллагын дүрэм, бүтэц орон тоо баталсан шийдвэрүүд, удирдлагын тушаал, нэгжүүдийн дүрэм, байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн төлөвлөгөө, түүний биелэлт, түүний биелэлт, санхүүгийн тайлан зэрэг баримт, материалуудыг цаасаар болон цахимаар хүргүүлж, нэмэлт, тайлбар мэдээлэл өгч ажиллав.

Олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал:

Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабаас өгсөн үүрэг даалгаврын дагуу “Дэм дэмэндээ” аяны хүрээнд Хан-Уул дүүргийн 9, 10, 16-р хорооны 9 өрхөд тус бүр 50000 төгрөгийн хүнс, ахуйн хэрэглээний бараа бүхий дэмжлэг, тусламж үзүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/779 дүгээр захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 9, 10 дугаар хороодыг хариуцан, тус хороодод сайжруулсан шахмал

түлшний нийлүүлэлт, түгээлт, борлуулалтын 9 цэгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллав.

Газрын даргын баталсан хуваарийн дагуу Хан-Уул дүүргийн 9, 10 дугаар хорооны түгээлтийн цэгүүдийн байршил, хүчин чадал, нөөцийн хэмжээ, түлшний чанар, хүртээмж бодит байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулж, түлш түгээлтийн цэгт ажиллаж байгаа иргэдээс ирсэн санал хүсэлт, тулгамдаж буй асуудлын талаар тухай бүр “Таван толгой түлш” ХХК-д мэдээлж ажиллав. Ажлын мэдээг долоо хоног тутам Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газарт enkhee5980@gmail.com, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтэст iska_1245@yahoo.com цахим хаягаар тус тус хүргүүлэн ажиллав.

Иргэдийн амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, аялагчдын эрүүл, аюулгүй байдлыг хангах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Богд хан уулын Баруун ширээтээс Дугуй цагаан руу алхдаг хэсэгт “Төгс хандлагаа өөрчилъе” ТББ-тай хамтран 2 га газарт 4000 мод тарих ажилд 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр нэгдэж эх дэлхийгээ хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйлсэд хувь нэмрээ оруулав.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас ирүүлсэн “Өгөөмөр өдөр” аянд 06 сарын 18-аас 27-ны өдрүүдэд хамрагдан оролцож, өөрт хэрэглэгдэхгүй бусдад өгч болох эд зүйлсийг цуглуулан Чингэлтэй дүүрэг хариуцсан төслийн мэргэжилтэнд хүлээлгэн өгөв.

Газрын даргын 2021 оны А/05 дугаар тушаалаар байгуулагдсан “Спорт хамтлаг”-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу албан хаагчдын дунд эрүүл, зөв амьдралын дадал хэвшүүлэх, дархлааг дэмжих зорилгоор “Цахим алхалт-2021” аяныг өрнүүлж, 76 албан хаагч амжилттай оролцсоноос 1-5 дугаар байранд оролцсон албан хаагчдыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав. Нийслэлийн Биеийн тамир, спортын хорооноос ирүүлсэн удирдамж, чиглэлийн дагуу гүйлт, алхалт, дугуй гэсэн төрлөөр 1 сарын аянд албан хаагчдаа идэвхтэй оролцуулсан.



Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй болгох, сурталчлан таниулах ажлын хүрээнд “Нээлттэй хаалганы өдөрлөг” Жанжин Д.Сүхбаатарын талбайд 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулав. Газраас үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээг иргэдэд үзүүлж, үйлчилгээний талаарх зөвлөгөө, мэдээлэл өгч, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар танилцуулав.



2021 оны 10 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн нийт албан хаагчдын хамт Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороо, Баруун салаа Бумбатын рашааны талбайд 80 ширхэг мод тарих өдөрлөгт оролцов.

2021 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-д байгууллагын нэрэмжит төгөл байгуулах ажлын эхлэх болох “Намрын мод тарих өдөрлөг” арга хэмжээнд нийт албан хаагч идэвхтэй оролцов.

2021 оны 11 дүгээр сарын 12-ноос 27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Хөдөлгөөнөөр дархлаагаа дэмжье” уриатай байгууллагын спортын 6 төрөлт тэмцээнд газрын хамт олон идэвхтэй оролцов.

Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд зохион байгуулагдсан спортын наадамд амжилттай оролцож Ажлын байрны дасгалын тэмцээнд Тэргүүн байранд шалгарсан.

Сайн үйлсийн аяны хүрээнд албан хаагчид “Цусаа хандивлах” үйл ажиллагаанд оролцсон.

Хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг даалгавар:

- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт;
- Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт;
- 150 мянган айлын орон сууцны үндэсний хөтөлбөрийн биелэлт;
- Нийслэлийн Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн биелэлт;
- Газрын эрх зүйн ажлын тайлан;
- Гадаад харилцааны ажлын тайлан;
- Ес зүйн зөрчлийн тайлан;
- Монгол Улсын Засгийн газрын 100 хоногт барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт;
- Газрын үйл ажиллагааны тайланг сар бүрийн 2, 4 дэх 7 хоногийн пүрэв гариг бүр chinzorigterka@gmail.com цахим хаягаар;
- Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/779 дүгээр захирамжийн хэрэгжилтийг 7 хоног бүр тайлагнаж ажиллав.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Нийслэлийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний төсөл”-д тусгах 86

арга хэмжээний саналыг 4 хавсралаар нэгтгэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэв.


4.7 Санаачлан хэрэгжүүлсэн ажил:

Улаанбаатар хотын түүхэн барилга, байгууламжийн хадгалалт хамгаалалтын судалгаа, шийдлийг боловсруулж холбогдох хурлаар хэлэлцүүлэх:

Улаанбаатар хотын түүхэн барилга байгууламж хадгалалт, хамгаалалт судалгааны ажлын хүрээнд Нийслэлийн хамгаалалтад авсан түүхэн өв соёлын байршил, засвар хийгдсэн байдал, зориулалтыг Нийслэлийн соёл урлагийн газар болон Дүүргүүдийн засаг даргын Тамгын газраас мэдээлэл авч, судалгаа боловсруулан, түүх соёлыг сэргээн засварлах, Соёлын өвийн тухай хууль эрх зүйн орчин, Соёлын өвийг хамгаалалтад авах олон улсын баримт бичиг болон Монгол улсын соёлын өвийн тухай хуульд нийцүүлэх талаар судалгаа хийв

Зарим Их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотуудад шилжүүлэх судалгаа, шийдэл боловсруулж холбогдох хурлаар хэлэлцүүлэх:

Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зарим Их дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотуудад шилжүүлэх судалгаа, төлөвлөлтийн шийдлийг тусган 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 05-ны өдрийн хооронд иргэд олон нийт, эрдэмтэн судлаачдын дунд шат дараалсан цахим хэлэлцүүлгүүдийг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай хамтран зохион байгуулсан.



Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн их дээд сургууль, коллежийн судалгаа хийгдсэн бөгөөд төлөвлөлтийн урьдчилсан шийдлийг Боловсрол, шинжлэх ухааны яам, Барилга хот байгуулалтын яам болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтарсан ажлын хэсэг байгуулж Засгийн газарт танилцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зарим их дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотуудад шилжүүлэх судалгаа болон төлөвлөлтийн шийдлийг тусгаж ажиллах тухай санал зөвлөмжийг 2021 оны 09 дүгээр сарын 20-24-ний өдрийн хооронд Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/715 захирамжаар байгуулагдсан мэргэжлийн чиглэлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-д хүргүүлсэн.



- Их дээд сургуулийн 99% нь Улаанбаатар хотод байдаг
- Нийт оюутны 7% нь дотуур байранд сүүдэг дотуур байрны хангамж муу
- Сургалтын орчин материаллаг бааз хүрэлцээгүй



ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ

94



157 628

ТӨРИЙН ӨМЧИТ



ХУВИЙН




ГАДААДЫН САЛБАР СУРГУУЛЬ



Баянзүрх дүүргийн 8, 9, 10, 17-р хороо, 42 га талбай, Сүхбаатар дүүргийн 20-р хороо, 2.4 га талбай, Сонгинохайрхан дүүргийн 29.9 га талбайд байнгын ундаргатай булгаар тэжээгдэж буй голын ай сав орчмын гадаргын усыг хуримтлуулж хөв цөөрөм үүсгэх тохижилтын ажлын төлөвлөлтийг боловсруулав.

Улаанбаатар хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор хотын хэмжээнд гудамж, барилга, байгууламжуудын өнгө төрх тэдгээрийн ансамблийг эвдэж буй хүчин зүйлсийг судлан хотын өнгө, төрхийн нэгдсэн шийдлийг тодорхойлох судалгааг хийв.



“ЦАХИМ БАРИЛГЫН МЭДЭЭЛЭЛ” гар утасны апплейкшны хөгжүүлэлтийг хийн танилцуулга, холбогдох мэдээллийг Нийслэлийн Засаг даргад танилцуулав.

“Барилгын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах” ажлыг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 19 дүгээр хурлаар танилцуулсан бөгөөд тус хурлын тэмдэглэлээр уг ажлыг эрчимжүүлэн, хэрэглээнд нэвтрүүлэх үүрэг өгөгдсөн. Үүрэг даалгаврын дагуу нийслэлийн 2022 оны төсөвт тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэрийг цахим болгох талаар судалгаа хийж www.mzh.uda.gov.mn хуудсаар дамжин дэмжсэн, эс дэмжигдсэн саналыг цахимаар өгөх веб программ хангамжийг шинээр боловсруулсан.

ТАВ. НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ, БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1 Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:


“Туул гол дагуу амралт, зугаалгын цогцолбор” байгуулах үзэл баримтлал /концепц/, загвар зураг боловсруулах уралдаан /Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/338 дугаар захирамж/

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/338 дугаар захирамжийн дагуу Иргэдийн амрах, зугаалах, чөлөөт цагаа ая тухтай, зөв боловсон өнгөрөөх орчин нөхцөлийг бий болгох зорилгоор “Туул гол дагуу амралт, зугаалгын цогцолбор” байгуулах үзэл баримтлал /концепц/, загвар зураг боловсруулах уралдааныг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд зарлан нийт 8 баг бүтээлээ ирүүлснийг 2021 оны 05 дугаар сарын 23-ны өдрийг дуустал цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулсан. Уралдаан дүгнэх комисс удирдамжид заасан шалгуур үзүүлэлтээр дүгнэн шилдгийн шилдэг санаа буюу тэргүүн байрт – 77.6 оноогоор “Riverside Paradise” бүтээл -15 сая төгрөг, 67.45 оноогоор “Оюут” ХХК дэд байрт шалгаран 5 сая төгрөгөөр тус тус шагнагдав.



Цагийн хязгаартай ажиллах авто машингүй гудамж, зам талбайн судалгаа гарган төсөл, хөтөлбөр боловсруулах /Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/292 дугаар захирамж

Бага тойруу орчимд 11 байршилд цагийн хязгаартай ажиллах гудамж, замын судалгаа боловсруулж, байршил тус бүрийн талбайн хэмжээ, онцлог үйл ажиллагааны чиглэлийг тусган, саналын хамт Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/292 дугаар захирамжаар байгуулагдсан Цагийн хязгаартай ажиллах авто машингүй гудамж, зам талбайн судалгаа гарган төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.



Өглөөний гудамж

Зарим үйлчилгээний байгууллагуудыг эрт цагийн хуваараар хагуулах, төрийн үйл ажиллагааны мэдээлэл бүтэцмөчлөг, төвлөрсөн байдалаар хүргэх.



Өглөөний дасгал

Биеийн тамир спортын арга хэмжээ, фитнес, илэр, бассейныг ажиллагааг эрт эхлүүлэх.



Өглөөний худалдаа

Соёл, боловсрол өмнө чиглэсэн худалдаа тухайн иргэдийн худалдаа, үзэсгэлэнг өглөө эрт эхлүүлэх.



Авто машингүй гудамж

Зарим гудамж, замыг биеийн болон цагийн хуваараар авто машингүй гудамж болгон ундааг дугуй, мөнгө ахалтыг дэмжих тухайн хэлцэт худалдаа, үйлчилгээний бичлэг бүтэцтэй болгох.




Шөнийн гудамж

Олон төрлийн худалдаа, үзэв, үйлчилгээ үзүүлдэг үндэс соёлын арга, хэмжээ, үзэсгэлэн тэнцэл зохион байгуулдаг шөнийн цагаар цагийн хуваараар үйл ажиллагаа жуулан гэрэл, талбайг бий болгох.



Шөнийн худалдаа

Нэг чөлөөтэй төрлийн үйлчилгээ үзүүлдэг ор болон шөнийн цагаар үйл ажиллагаа жуулан цагийн хуваараар гудамж, талбайг бий болгох.



Цагийн хуваарийн дагуу ажиллах олон нийтийн талбай



Цагийн хуваарийн дагуу ажиллах гудамж



Авто машингүй гудамж

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах чиглэлээр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын цогц арга хэмжээ авах /Нийслэлийн Засаг даргын 2021 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/393 дугаар захирамж/

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, нийтийн тээврийн хүртээмж, чанарыг сайжруулах, дэвшилтэд технологи бүхий багтаамж ихтэй шинэ нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ тойрог зам барих, хот төлөвлөлтийн бодлогын хүрээнд олон төвтэй эдийн засаг, санхүү бизнесийн хот байгуулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор "Улаанбаатар хотын төвлөрлийг зохицуулах нэгдсэн хөтөлбөр"-ийн төлөвлөгөөг боловсруулах юм. Уг хөтөлбөр нь найман салбарыг хамарсан 5 үндсэн чиглэлээр хийгдэх бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдээс бүрдэнэ. /Нийслэлийн авто замын түгжрэл, төвлөрлийг сааруулахад чиглэсэн авто замын оновчтой сүлжээг бий болгож замын орц гарцыг нэмэгдүүлэх, гэр хорооллын нөхцөлийг сайжруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дэмжсэн төсөл арга хэмжээ/

Тус газраас Ажлын хэсэгт Улаанбаатар хотын хүн ам, барилгажилтын нягтралын судалгаа, мэдээллийг гарган нэгтгэж, дэд төвийн төлөвлөлтийн хэрэгжилт, цаашид хийгдэх ажлыг тодорхойлох байршлын зураглал, хөрөнгө оруулалтын тооцоог, дэд төвийн төлөвлөлтийг хэрэгжүүлснээр гарах үр дүнг зураглал хэлбэрээр танилцуулга, дэд төвийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулахад шаардагдах хөрөнгө оруулалтын болон бүтээн байгуулалтын тооцоог гарган хүргүүлэв.

Ажлын хэсгээс Монгол Улсын Ерөнхий сайдын ахалж буй "Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, автозамын түгжрэлийг бууруулах" үндэсний хорооны 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоо судалгааны материалыг бэлтгэв.

Гандантэгчэнлин хийдийн одоогийн байдал болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө:

"Гандантэгчэнлин хийд" орчмыг соёл, аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх ажлын хүрээнд Гандантэгчэнлин хийд орчмын одоогийн байдал, хийгдсэн төлөвлөлтүүд, төсөл хөтөлбөрийн талаар Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 7 дугаар хуралд танилцуулан, Монгол Улсын Засгийн газрын 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Гандантэгчэнлин хийд" орчимд аялал жуулчлалын бүс байгуулах, төлөвлөлтийг хэлэлцүүлэн, хурлын тэмдэглэлээр үүрэг өгөгдөв.

ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙДИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

/ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ/



Богдхан уул-Дугуй цагаан чиглэлийн явган аяллын замын тохижилтын ажил /Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/370 дугаар захирамж/

Иргэдийн амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, аялагчдын эрүүл, аюулгүй байдлыг хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Богдхан уул-Дугуй цагаан чиглэлийн явган аяллын замыг тохижуулах ажлын даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 8 дугаар хурлаар хэлэлцэн МЗХ2021/08-002 дугаар тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгаврыг батлуулж, загвар зураг боловсруулах ажилд хяналт тавин ажиллаж байна.

Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо “Аса” цирк орчмын 1,8 га талбай Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэнг байгуулах, Одоо байгаа Н.Нацагдоржийн номын санг шинэчлэн төлөвлөж ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН СОЁЛЫН ТӨВ болгох төлөвлөлтийг боловсруулж танилцуулав.



Нийслэлийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/374 дугаар захирамжаар Нийслэлийн нутаг дэвсгэрт агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээг бодитой үр дүнд хүргэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор “Эко орчин-цэвэр агаар” аяныг 2021 оны 05 дугаар

сарын 18-ны өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар, Нийслэлийн Авто замын хөгжлийн газартай хамтран гудамжны судалгааг гарган дүүрэг бүрд тухайн гудамжны хамаарал бүхий газар ашиглагч, эзэмшигч, өмчлөгч үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэний оролцоог хангуулан жишиг байдлаар тохижуулах гудамжийг сонгов. Үүнд:

1. СҮХБААТАР, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ: Чингэлтэйн өргөн чөлөө, (32-ын аюулгүйн уулзвараас хойд зүг 17-гийн автобусны буудал хүртэл 1,2 км),
2. БАЯНГОЛ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ: Хувьсгалын зам, (Тасганы овооны аюулгүйн уулзвараас хойд зүг МҮОНРТ хүртэл 0,4 км)
3. БАЯНГОЛ, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ: Ард Аюушийн өргөн чөлөө, (Саппорогийн аюулгүйн уулзвараас хойд зүг хорооллын автобусны эцсийн буудал хүртэл 1,7 км)
4. СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ: Товчооны зам, (Моносын аюулгүйн уулзвараас баруун зүг Дархан хот баруун аймаг салах аюулгүйн тойрог хүртэл 8,9 км)
5. ХАН-УУЛ ДҮҮРЭГ: Чингисийн өргөн чөлөө “УБЦС” ХК-ийн уулзвараас хойд зүг Үйлдвэрчний гудамж үйлдвэр урлалын дээд сургууль хүртэл хойд зүг хүртэл 0,53 км,
6. БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ: Дандарбаатарын гудамж, (Скадрилын хөшөөнөөс хойд зүг Цайз зах хүртэл 0,94 км)

5.2 Бусад байгууллагуудтай хамтран ажилласан ажлын талаар:

Нийслэлийн Засаг даргын А/318 захирамжийн дагуу Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны захиалгаар “Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Газар дэлхий” ХХК шалгарсан. Тус бодлогын баримт бичгийг боловсруулахад хот байгуулалтын суурь судалгаа, “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040”-ын үзэл баримтлалыг хүргүүлж хамтран ажиллав.

Улаанбаатар хотын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах төлөвлөгөөний саналыг боловсруулж тоон хэлбэрээр /Arcgis программ/ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.

Улаанбаатар хотын 1938-2020 оны ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотын суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн тэлэлт, түүхэн барилга байгууламжийн талаар 26 хуудас бүхий танилцуулгыг боловсруулж постер бэлтгэн танилцуулж ажилласан.



Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/121 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу зөвшөөрөлгүй баригдсан 102 барилгын асуудлыг

шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/295 дугаар захирамж батлагдав. Үүнээс:

- Буулгах шийдвэр гарсан 22 барилга /хяналт хэрэгжүүлэгч байгууллагад үүрэг болгож судалж байгаа/
- Хууль тогтоомжид нийцүүлэн архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон-12, Загвар зураг баталсан-3,
- Барилга угсралтын ажлаа бүрэн гүйцэтгэн дуусаж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажилласан 4 барилга
- Бичиг баримтын бүрдэл хангуулж, зөрчил арилгуулсан 20 барилгад барилгын ажлын зөвшөөрөл олгов.
- Барилгын ажлын зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 2 барилгын бичиг баримтын бүрдлийг хянаж байна.

Үлдсэн 39 барилгын захиалагч, гүйцэтгэгч нарт зөрчлөө арилгах талаар зөвлөгөө өгч ажилласан.

“Одон орон, геофизикийн хүрээлэн”-гээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Хүчтэй газар хөдлөлтийн баллыг тодорхойлох багаж, төхөөрөмжийг Улаанбаатар хотын 4 бүсэд суурилуулан урт хугацаанд хамтран хэмжилт, судалгаа хийх талаар санамж бичиг байгуулахаар болов.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Нийслэлийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах, ажиллах журам батлах тухай” А/247 дугаар захирамжийг хэрэгжүүлж, аж ахуй, нэгж, байгууллагын барилгуудыг гамшгийн үед өмчийн хэлбэрээс үл хамаарч түр орон байрны зориулалтаар ашиглах нөхцөлийг бүрдүүлж, объект тус бүр дээр ажиллах орон тооны бус штабыг томилгоожуулах, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан баталж, шаардлагатай гэж үзвэл гэрээ байгуулах, хяналт тавих, сургалт, арга зүйгээр ханган ажиллаж, Нийслэлийн Түр орон байраар хангах албанд тайлагнаж, хамтран ажиллах талаар 05/3851 дүгээр албан бичгийг Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газарт тус тус хүргүүлэв.

Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын авто зам, тохижилт, ногоон байгууламжийг ашиглах хамгаалах журмын дагуу орц, гарц гаргах хүсэлт гаргасан аж ахуй, нэгж байгууллагуудын хуралд цахимаар оролцож батлагдсан эх загвар зурагт тайлбар мэдээлэл өгч ажиллав.

Барилга хот байгуулалтын яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Барилга, архитектурын сургуультай жил бүр хамтран зохион байгуулдаг эрдэм шинжилгээний УЛААНБААТАР УС-ЦЭВЭР ОРЧИН 2021 бага хуралд оролцож, Инженерийн бэлтгэл арга хэмжээний шугам сүлжээ болон Ус хангамж ариутгах татуургын шугам сүлжээний одоогийн байдал, төлөвлөлт, шинэ технологи, усны аюулгүй байдал нэртэй илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Дэд бүтцийн төвийн халаалтын зуух, цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоон SHP файлаар нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдөр 06/1439 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1255 дугаар захирамжаар Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төслийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төслийг эрчимжүүлэх, асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын Хот байгуулалтын асуудал хариуцсан Төслүүдийн удирдагчаар ахлуулан 6 удаа хуралдаж, хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Нийслэлийн 9 дүүргээс сонгогдсон Монгол Улсын Их Хурлын гишүүд, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч нарт төсөл хэрэгжүүлэх санал ирээгүй, Улсын төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байгаа нийтийн зориулалттай орон сууцны барилгын сууц өмчлөгчдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах тухай албан бичиг хүргүүлсэн.

ДУГНЭЛТ:

- Хөгжлийн баримт бичиг болон шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг тухай бүр хяналтад авч, хэрэгжилтийг хангуулан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийг мөрдлөг болгон хяналт-шинжилгээ, үнэлгээг хийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн нягталж, хэрэгжилтийн мэдээг холбогдох дээд газарт хүргүүлэн ажиллаж байгаа нь газрын үйл ажиллагаа, төрөөс баримтлах урт дунд, богино хугацааны төсөл хөтөлбөрүүдтэй уялдан хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж байна.
- Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажилд салбар хоорондын уялдаа холбоог сайн хангуулан ажилласан.
- Дүрмээр хүлээсэн үүргээ хангалттай хэрэгжүүлж “Хүний нөөцийн хөгжил” хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хэрэгжиж, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тал дээр сайн ажилласан.
- Газрын uda.ub.gov.mn цахим хуудсанд мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн баяжуулж MNS 6285:2011 стандартыг мөрдлөг болгон ажиллаж байгаа нь иргэн, хуулийн этгээдэд үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод, нээлттэй, шуурхай хүргэх үндэс болсон.
- Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд онцгой анхаарч, зөрчлийн мэдээг албан хаагч нэг бүрээр гарган Захиргааны зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн арга хэмжээ авч, Үр дүнгийн гэрээнд тооцон ажиллаж байгаа нь албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чанарт ахиц гарахад нөлөөлсөн байна.

ЦААШИД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТОТ АЖИЛ:

- ✓ “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г батлуулж, мөрдөж ажиллах
- ✓ Хот байгуулалтын салбарын эрх зүйн орчныг илүү оновчтой болгох
- ✓ Төвлөрлийг сааруулах, түгжрэлийг багасгах цогц арга хэмжээний төлөвлөлтийг боловсруулах
- ✓ Тохижилт, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, шинэ байршлыг судлах
- ✓ Улаанбаатар хотын барилга байгууламжийг өнгөний нэгдсэн шийдэлтэй болгох

ТАНИЛЦСАН: ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН ГАРГАСАН: МЭРГЭЖИЛТЭН



Ц.ТУЛГА

Ч.БАДАМХАНД

Л.ЭНХТУУЛ